



Огноо: 2025.11.25

“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн Наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн.” гэж хуульчилсан бөгөөд Монгол хэлний тухай хуулийн 4.1.1-д “төрийн албан ёсны хэл” гэж төрийн байгууллага, хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөх орчин цагийн утга зохиолын монгол хэлийг” ойлгоно гэж, 6.1.7-д “газар нутаг, засаг захиргааны нэгж, гудамж, зам, талбай, хуулийн этгээдийн нэр, хаяг”-ийг монгол хэлээр хөтлөн явуулна гэж тус тус заасан.

Геодези, зураг зүйн тухай хуулийн 11.3.1-д “эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объектын нэр газар зүйн нэрэнд хамаарна.” гэж, 5.1.3-т “Улсын Их Хурал газар зүйн нэрийг батална.” гэж, 11.8-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах газар зүйн нэрийг Засгийн газар нэгтгэн Улсын Их Хурлаар батлуулна.” гэж, мөн хуулийн 5.1.3-т “Улсын Их Хурал газар зүйн нэрийг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан бөгөөд Монгол Улсын 2005 онд нэгдэн орсон ЮНЕСКО-ийн 2003 оны Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцод “Улсын Их Хурлаар албажуулан баталсан нэрийг сум, дүүргийн Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран хамгаална.” гэж заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хилийн цэс, газар орны нэрийг хууль бусаар албан ёсны баримт бичиг, газар зүйн зурагт өөрчилсөн болон албан ёсны баримт бичиг, арга хэмжээнд газар усны давхар нэр хэрэглэсэн, монгол хэлнээс бусад хэлээр орчуулсан, эсхүл бусад хэлний дуудлагаар галиглан бичсэн тохиолдолд хууль зөрчсөн гэмт хэрэг, зөрчилд тооцож, ял, шийтгэл оногдуулахаар Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуульд тус тус заасан.

1.2. Практик шаардлага:

“Газар нутгийн нэрийг тодруулан тогтоож, журамлах зарим арга хэмжээний тухай” Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 280

дугаар тогтоолоор Газар нутгийн нэрийн байнгын комиссийг байгуулж, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг 1980-1985 онд хийж, улмаар "Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай" Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор "Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт"-ыг баталж, газар зүйн нэрийн жагсаалтыг 4 жил тутам тодотгож, Улсын Их Хурлаар батлуулахыг Засгийн газарт үүрэг болгосон.

Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан нийт 214805 газар зүйн нэрийг бүх төрлийн масштабтай байр зүйн болон газрын зураг, атласт тусган тэмдэглэж, улсын хил тогтоох, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тусгай хэрэгцээний газрын байршил, хил заагийг тогтоох, хаягжуулах, соёлын өвийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд ашиглагдаж байна.

Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах 8767 газар зүйн нэр, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах 6941 газар зүйн нэр батлагдсан. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019-2025 онд 16 аймгийн 114 сум, нийслэлийн 4 дүүргийн "Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн ажил"-ыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2020-2021 онд Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан монгол хэлнээс өөр хэл дээр байгаа газар зүйн нэрийн судалгааг Баян-Өлгий, Увс, Ховд, Дархан-Уул, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад хийсэн байна.

Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэрүүд нь 1980-1985 оны хооронд хийгдсэн нэрийн тодруулалтаар тогтоогдсон нэр бөгөөд тухайн үеийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн дагуу батлагдсан. Өөрөөр хэлбэл, 1985 оноос хойш байгуулагдсан 3 аймаг (Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр), 30 сумын нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэр тухайн үеийн засаг захиргааны нэгжийн нэртэйгээр батлагдсан байгаа нь ижил төстэй нэрийг байршлаар нь гуйвуулан хэрэглэж, засаг захиргааны нэгжийн хилийн цэстэй холбоотой маргаан гарахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Эрдэмтэн А.Д.Симуковын зохиож, 1938 онд хэвлэгдсэн БНМАУ-ын газрын зурагт тэмдэглэгдсэн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын нутаг дэвсгэрийн хамгийн баруун захын цэг болох Мааньт уулын нэрийг одоог хүртэл Улсын Их Хурлаар баталгаажуулан батлуулаагүй, ерөнхий боловсролын сургуулийн газар зүйн хичээлийн сурах бичигт тэмдэглэж олон нийтэд хэрэглэгдэж байна.

Түүнчлэн, Монгол Улсын хилийн дагуу байрлах, 3000 метрээс дээш өндөртэй зарим уулын нэрийг ашиглагдаж байгаа уламжлалт нэрээр нь баталгаажуулж, хэрэглээнд нэвтрүүлэх, олны хүртээл болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар усны нэрийн талаар

Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах монгол хэлнээс өөр хэл дээр батлагдсан 319 газар зүйн нэр байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Газрын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн дээрх зөрүүтэй газар зүйн нэрүүдийг монгол хэл дээр зөв нэрээр нь баталснаар хойч үедээ газар зүйн үнэн зөв нэрийг өвлүүлэн үлдээх төдийгүй Монгол

Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгахад нэн чухал болно.

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах газар зүйн нэрийг 1:100000-ны масштабтай байр зүйн зураг, бусад баримтаас судалж, 400 газар зүйн нэр монгол хэлнээс өөр хэл (казах, орос, тува г.м) дээр нэрлэгдсэн байж болзошгүйг тогтоосон. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2022 онд энэ асуудлаар зөвлөмж гаргаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын захирамжаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, 2023 оны 3-9 дүгээр сарын хугацаанд 218 газар зүйн нэр монгол хэлнээс бусад хэл дээр байгааг суурин судалгаагаар тогтоож, 97 нэрийг газар дээр нь судалж тодруулах шаардлагатай гэж үзсэн байна.

Дээрх ажлын хүрээнд 2023 оны 06 дугаар сард хээрийн судалгааны ажлыг Баян-Өлгий аймгийн 9 сумын нутаг дэвсгэрт хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны явцад газар зүйн нэрийг шууд орчуулж нэрлэсэн 100, төсөөтэй байдлаар өөрчлөн нэрлэсэн 142, домог, түүх шинээр зохиож нэрлэсэн 4, хүний нэрээр нэрлэсэн 44, болсон үйл явдлаар хамаатуулан нэрлэсэн 7 нэр тус тус байсныг тогтоож, 47 газар зүйн уламжлалт нэрийг шинээр нэмж илрүүлсэн байна.

Мөн Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах Монгол Алтайн нурууны мөсөн бүрхүүл бүхий зарим уул, оргил, толгой ("Доод хоног толгой", "Суварга оргил", "Бүргэд оргил", "Наран оргил", "Өлгий оргил", "Хар Ямаат уул")-н нэрийг уулчид, дотоодын болон гадаадын аялагчид олон жил ашиглаж ирсэн боловч албан ёсны газар зүйн нэр болж батлагдаагүй байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан, Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гурван улсын хэлэлцээрээр батлагдсан гурван улсын уулзварын цэг болох "Таван Богд уул"-ыг орон нутгийн иргэд "Найрамдал-2", "Хүйтэн уул"-ыг "Найрамдал-1" гэх мэтээр андуу ташаа нэрлэж байгаа тул үнэн зөв нэрийг таниулан сурталчлах, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Газрын тухай хуулийн зохицуулалтад нийцүүлэн Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах, монгол хэлнээс өөр хэл дээр батлагдсан 319 нэрийг монгол оноосон нэрээр нь шинэчлэн батлах, иргэд, олон нийтийн одоо ашиглаж байгаа 47 газар зүйн уламжлалт нэрийг нэмж Улсын Их Хурлаар баталгаажуулж, хойч үедээ газар зүйн үнэн зөв нэрийг өвлүүлэн үлдээх нь нэн чухал байна.

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах газар үсны нэрийн талаар

Сүхбаатар аймгийн 13 сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2021-2022 онд орон нутгийн төсвөөр гүйцэтгэж, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 1980-1984 онд хийж гүйцэтгэсэн хээрийн тодруулалтаар тогтоосон газар зүйн нэрийг 1:100000-ны масштабтай байр зүйн зураг дээр тэмдэглэн хэрэглэж байгаа хэдий ч Улсын Их Хурлаар батлуулаагүй 940, байрлал зөрүүтэй 17, үг, үсгийн зөрүүтэй буюу хэл бичгийн дүрмийн алдаатай 45 газар зүйн нэр байгааг тогтоож, мөн хээрийн тодруулалтаар уламжлалт 1080 нэрийг шинээр тогтоосон байна.

Дээрх тогтоосон газар зүйн нэр бүрт хувийн хэрэг үүсгэж, мэдээллийн сан бүрдүүлэн, газар зүйн нэрийн зургийг сум бүрээр зохион үйлдэж, тухайн сум, аймгийн Газар зүйн нэрийн салбар зөвлөл, сумын, аймгийн Иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлаар тус тус хэлэлцүүлж, Улсын Их Хурлаар батлуулахыг дэмжсэн байна.

Сүхбаатар аймагт хийгдсэн Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын үр дүнд шинээр (уламжлалт) бий болсон нэр, өөрчлөлт орох нэр, байрлал зөрүүтэй зэрэг нийт 2220 нэрэнд хяналт, шалгалт хийж зөвлөмж, дүгнэлт гаргах ажлыг Барилга, хот байгуулалтын яам, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Усны газар, Шинжлэх ухааны академи, Сүхбаатар аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэрэгжүүлсэн.

Иймд дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик хэрэгцээ, шаардлагын дагуу Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийг Улсын Их Хурлаар батлуулах зорилгоор "Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай" Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулна.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Улсын Их Хурлын тогтоолын төсөл 3 заалттай бөгөөд 1 дэх заалтад "Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт"-д казак хэл дээр болон зөрүүтэй нэрээр батлагдсан газар зүйн нэрүүдийг өөрчлөн батлах, 2 дахь заалтад шинээр нэмж тогтоосон газар зүйн нэрүүдийг батлах, 3 дахь заалтад тогтоол батлагдсантай холбогдуулан "Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт"-ын дагуу Баян-Өлгий аймгийн сумдын хилийн цэсийг шинэчлэн тогтоох асуудлыг Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх болон геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд батлагдсан газар зүйн нэрийг бүртгэж, нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох зохицуулалтыг тус тус тусгана.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Тогтоолын төсөл батлагдсанаар газар нутаг, байгаль орчноо хамгаалах, хадгалах, хойч үедээ газар нутгаа хайрлан хамгаалах үзэл бодол, төлөвшлийг өвлүүлэн үлдээхэд чухал ач холбогдолтой.

Түүнчлэн, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон түүх, соёл, өв уламжлалд харшилсан, хууль тогтоомж зөрчиж газар зүйн нэрийг өөрчлөн хэрэглэх явдлыг таслан зогсооно.

Тогтоолоор зохицуулах харилцаа нь нийгэм, эдийн засгийн аливаа сөрөг үр дагавар үүсгэхгүй бөгөөд тогтоолын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах уулчдын авирдаг, хоноглодог мөсөн уул, толгой, оргилын нэр, солбицол, өндрийг газар дээр нь самбарт холбогдох стандартын байрлуулж тэмдэгжүүлнэ;

1. Зөрүүтэй газар зүйн нэрийг газрын зураг дээрээс арилгаж, өөрчлөгдөж, шинээр батлагдсан газар зүйн нэрийг газрын зураг дээр тэмдэглэж, иргэд, олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ;

2. Газар зүйн нэрийг албан ёсны баримт бичигт болон иргэд, олон нийтийн хэрэглээнд монгол хэл дээр үнэн, зөвөөр тусгаж, төр, захиргааны бүх шатны байгууллага, иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, мэдэгдэнэ.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал:

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд бүрэн нийцэх бөгөөд бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй. Тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулна.

-----o0o-----